



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/92

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 103 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит бус XIII дугаар хуралдааны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ сэргэлтийн бодлого”, “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн зорилтыг хангах, “Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага”-ыг дэмжих ажлын хүрээнд “Нээлттэй-Хөвсгөл” сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах зардалд 5.040.000 (таван сая дөчин мянга) төгрөг, Улаанбаатар хотод зохион байгуулагдах “Хөдөөгийн сэргэлт” чуулганд оролцож аймгийн онцлог, давуу тал, шилжин суурьшигчдыг хүлээн авах бодлого төлөвлөгөө танилцуулж, хотоос хөдөө рүү шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн танилцуулга хийх, иргэд, олон нийтээс сонирхсон асуултад хариулт өгч мэдээлэл хүргэх үйл ажиллагааны зардалд 5.289.520 (таван сая хоёр зуун наян есөн мянга таван зуун хорь) төгрөг, нийт 10.329.520 (арван сая гурван зуун хорин есөн мянга таван зуун хорь) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 10.329.520 (арван сая гурван зуун хорин есөн мянга таван зуун хорь) төгрөгийг Засаг дарга дансны “Төсөл арга хэмжээний бэлтгэл хангах зардал”-аас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6711010396